



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 5/78

Хэрлэн сум

**С.Лхагвацэрэнд сахилгын
шийтгэл ногдуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4, 48.1.3 дахь заалт, Монгол Улсын Сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл оногдуулах, түүнд гомдол гаргах журам"-ын 3.6, 5.1 дэхь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хүндэтгэн үзэх шалтгаангүй, удаа дараа зөрчил гаргасан Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн Сүхбаатарын Лхагвацэрэнд албан тушаалын цалингийн хэмжээг 1 сар 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.С.Лхагвацэрэнгийн цалингаас зохих суутгал хийж олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д даалгасугай.

3.С.Лхагвацэрэнгийн төрийн албан хаагчийн хувийн хэрэгт холбогдох журмын дагуу баяжилт хийхийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Ш.Эрдэнэжаргал)-д даалгасугай.

4.Төрийн албаны тухай хууль болон, холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын дотоод журмыг сахиж өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллахыг С.Лхагвацэрэнд үүрэг болгосугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Ч.Баярцолмон)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНТУЛГА

